



## БАЯНХОНГОР АЙМАГТ 2021 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2022 оны 01 дүгээр сарын 05

Номгон

### НЭГ: ХҮЛЭЭН АВСАН ГОМДОЛ МЭДЭЭЛЛИЙН ТАЛААР:


2021 онд нийт 4516 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 328 нэгжээр буюу 6.7 хувиар буурсан. Үүнээс:



Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 142 буюу 13.3 хувийг 5 хоногт, 870 буюу 81.6 хувийг 6-19 хоногт, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 3313 буюу 96 хувийг 5 хоногт, 81 буюу 2.3 хувийг 6 ба түүнээс дээш хоногт тус тус шалгаж шийдвэрлэсэн.


### ХОЁР: БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ:

Аймгийн хэмжээнд 2021 онд 428 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 34 нэгжээр буюу 7,4 хувиар буурсан. Бүртгэгдсэн гэмт хэргийн 239 буюу 55.8 хувь нь Баянхонгор суманд 189 буюу 44.1 хувь нь бусад суманд үйлдэгдсэн.




/Гэмт хэргийн гаралт сүүлийн 5 жил/


### 2.1 Гэмт хэргийн гаралтыг багаар нь харьцуулсан байдал



### 2.2 Гэмт хэргийн гаралтыг сумдаар нь харьцуулсан байдал




## 2.3 Баг, сумдын гэмт хэргийн илрүүлэлт /2021 он/



Энэ хугацаанд хэрэг бүртгэлтийн 210 хэрэг бүртгэгдсэнээс 119 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж гэмт хэргийн илрүүлэлт 56.7 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1 пунктээр буурсан.

### 2.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал:

Бүртгэгдсэн гэмт хэргийн 352 буюу 82.2 хувь нь хөнгөн ангиллын, 76 буюу 17.7 хувь нь хүнд ангиллын гэмт хэрэг бүртгэгдсэн.



### 2.5 Бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн зүйл ангиар, өсөлт, бууралт/:

№	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2020 сар	2021 сар		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	7	6	-14.2%	1.4%
	Үүнээс: Илрүүлэлтийн хувь	100%	66.7%	33.3 пункт	
	Хүнийг алах	2	3	50%	0.7%
	Үүнээс: Илрүүлэлтийн хувь	-	50%		
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	143	179	25.2%	41.8%
	Үүнээс: Илрүүлэлтийн хувь	80.5%	81.8%	1.3 пункт	
	Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	6	4	-33.3%	0.9%
	Үүнээс: Илрүүлэлтийн хувь	100%	-	-100 пункт	
	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	2	0	-100%	0
	Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах	7	8	14.3%	1.9%
Үүнээс: Илрүүлэлтийн хувь	100%	100%	-		


	Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах	126	162	28.6%	37.9%
	Үүнээс: Илрүүлэлтийн хувь	78.5%	83.3%	4.8 пункт	
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	30	21	-30%	4.9%
	Үүнээс: Илрүүлэлтийн хувь	63.6%	71.4%	7.8 пункт	
	Хүчиндэх	22	16	-27.2%	3.7%
	Үүнээс: Илрүүлэлтийн хувь	53.6%	56%	2.4 пункт	
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	0	2	100%	0.5%
	Үүнээс: Илрүүлэлтийн хувь	-	0	-	-
5	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	192	145	-24.5%	33.8%
	Үүнээс: Илрүүлэлтийн хувь	39%	31.5%	-7.5 пункт	
Үүнээс	Хулгайлах	80	67	-16.2%	15.7%
	Үүнээс: Илрүүлэлтийн хувь	44.2%	27.8%	-16.4%	
	Залилах	28	38	35.7%	8.9%
	Үүнээс: Илрүүлэлтийн хувь	23.1%	25%	-1.9 пункт	
	Дээрэмдэх	1	4	75%	0.9%
	Үүнээс: Илрүүлэлтийн хувь	0	66.7%	66.7 пункт	
	Мал хулгайлах	66	21	-68.1%	4.9%
	Үүнээс: Илрүүлэлтийн хувь	40%	38.5%	-1.5 пункт	
	Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших	6	5	-16.6%	1.1%
	Үүнээс: Илрүүлэлтийн хувь	60%	100%	40 пункт	
	Хөрөнгө завших	7	5	-28.5%	1.2%
	Үүнээс: Илрүүлэлтийн хувь	50%	0%	-50 пункт	
	Эд хөрөнгө устгах, гэмтээх	4	3	-25%	0.7%
Үүнээс: Илрүүлэлтийн хувь	0%	100%	100 пункт		
6	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	4	1	-75%	0.2
	Үүнээс: Илрүүлэлтийн хувь	66.7%	0%	-66.7 пункт	
7	Авлигын эсрэг гэмт хэрэг	5	0	-100%	-
8	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	5	7	40%	1.6%
9	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	53	27	-59%	6.3%
	Үүнээс: Илрүүлэлтийн хувь	70.4%	66.7%	-3.7 пункт	
10	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	25	19	-24	4.4%
	Үүнээс: Илрүүлэлтийн хувь	77.3%	83.3%	6 пункт	

## 2.6 Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал /онцлог/

Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал	2020 он	2021 он	Нэгжээр	Өсөлт бууралт /хувиар/
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	44	46	2	4.5%
Эмэгтэй хүн оролцсон	37	45	8	21.6%
Хүүхэд оролцсон	18	27	9	50%
Бүлэглэн гүйцэтгэсэн	52	40	-12	-23%

Согтуугаар	127	171	44	34.6%
------------	-----	-----	----	-------

## 2.7 Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн газар, гараг, цаг хугацаа:



Баянхонгор аймагт бүртгэгдсэн 428 гэмт хэргээс 184 буюу 42.9 хувь нь гэр орон сууцанд, 40 буюу 9.3 хувь нь гудамж талбайд, 28 буюу 6.5 хувь нь олон нийтийн газар, 5 буюу 1.1 хувь нь төрийн байгууллагад, 15 буюу 3.5 хувь нь авто замд, 149 буюу 34.8 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.

### Хэрэг үйлдэгдсэн цаг:

- ❖ 06-14 цагийн хооронд 97 гэмт хэрэг үйлдэгдэж нийт хэргийн 22.6 хувийг,
- ❖ 14-19 цагийн хооронд 127 гэмт хэрэг үйлдэгдэж 29.6 хувийг,
- ❖ 19-22 цагийн хооронд 96 гэмт хэрэг үйлдэгдэж 22.4 хувийг,
- ❖ 22-06 цагийн хооронд 108 гэмт хэрэг үйлдэгдэж нийт хэргийн 25.2 хувийг тус тус эзэлж байна.




### Хэрэг үйлдэгдсэн гараг:

- Даваа гарагт 57 гэмт хэрэг үйлдэгдэж нийт хэргийн 13.3 хувийг,
- Мянмар гаригт 73 гэмт хэрэг үйлдэгдэж нийт хэргийн 17 хувийг,
- Лхагва гарагт 65 гэмт хэрэг үйлдэгдэж 15.1 хувийг,
- Пүрэв гарагт 60 гэмт хэрэг үйлдэгдэж 14 хувийг,
- Баасан гарагт 72 гэмт хэрэг үйлдэгдэж 16.8 хувийг,
- Бямба гарагт 45 гэмт хэрэг үйлдэгдэж 10.5 хувийг,
- Ням гарагт 56 гэмт хэрэг үйлдэгдэж нийт хэргийн 13 хувийг тус тус эзэлж байна.

### Гурав: Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Энэ хугацаанд нийт 391 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9 нэгжээр буюу 2.2 хувиар буурсан бөгөөд үүнээс 45 буюу 11.5 хувь нь эмэгтэй хүн холбогдон шалгагдсан байна.


Гэмт хэрэгт холбогдогчдыг насны ангилалаар авч үзвэл:



### 3.1 Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, байгууллага:

Гэмт хэргийн улмаас 433 иргэн хохирч, үүнээс 196 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 25 нэгжээр буюу 14.6 хувиар өсч, 14 хүн нас барсан нь өмнөх оны мөн үетэй ижил байна.

Гэмт хэргийн улмаас 1000.0 сая төгрөгийн хохирол учирснаас 438.0 сая төгрөгийг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 43.8 хувьтай байна.



## ДӨРӨВ: ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН УЛМААС ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭ

4.1 Тус газарт 2021 оны 12 дугаар сард 428 бүртгэгдсэн гэмт хэргийн 46 буюу 10.7 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 2 нэгжээр буюу 4.5 хувиар өссөн.

### 4.2 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг:



## ТАВ: ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ



Аймгийн хэмжээнд 2021 оны 12 дугаар сард нийт 17722 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8699 зөрчлөөр буюу 32.5 хувиар буурсан байна. Бүртгэгдсэн зөрчлийн 17587 буюу 99.2 хувийг шийдвэрлэсэн байна.

Зөрчил гаргасан 14915 иргэнийг ердийн журмаар 451039.7 төгрөгөөр, 2010 иргэнийг хялбаршуулсан журмаар 528775.0 мянган төгрөгөөр, зөрчлийн хэрэг нээн шалгаж 91 иргэнийг зөрчлийг 22135.0 мянган төгрөгөөр

торгосон.

### Өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Дээрх хугацаанд шүүгчийн захирамжаар 562 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан нь 92 нэгжээр буюу 20.6 хувиар, 887 иргэн торгож, жолоодох эрх хассан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 272 нэгжээр буюу 44.2 хувиар тус тус өссөн байна.

#### 5.1 Зөрчил үйлдэгдсэн онцлог

Зөрчил үйлдэгдсэн байдал	2020.12 сар	2021.12 сар	/Өсөлт,бууралт/	Хувиар
Согтуугаар	1724	1833	109	6.3%
Хүүхэд оролцсон	9	19	10	1.1 дахин
Эмэгтэй хүн оролцсон	186	280	94	50.5%
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	150	206	56	37.3%
Олон нийтийн газар	314	98	-216	-68.8%
Гэр орон сууцанд	388	548	160	41.2%
Гудамж талбайд	1330	1868	538	40.5%


#### 5.2 Зөрчил үйлдэгдсэн цаг хугацаа, гарагийг нийт зөрчилтэй

Зөрчил гарсан цагаар нь:		Зөрчил гарсан өдрөөр нь:	
06-12 цагт	4748 буюу 26.8%	Даваа гараг	2763 буюу 15.6%
		Мягмар гараг	2820 буюу 15.9%
13-18 цагт	8031 буюу 45.3%	Лхагва гараг	2737 буюу 15.4%
		Пүрэв гараг	2834 буюу 16%
19-24 цагт	4146 буюу 23.4%	Баасан гараг	2745 буюу 15.5%
		Бямба гараг	2026 буюу 11.4%
01-05 цагт	797 буюу 4.5%	Ням гараг	1797 буюу 10.1%

харьцуулсан эзлэх хувь:

#### 5.3 Зөрчил үйлдсэн иргэдийг нийгмийн байдлаар нь авч үзвэл:

Энэ хугацаанд 2672 иргэн зөрчилд холбогдон шалгагдсанаас 471 буюу 17.6 хувь нь эмэгтэй, 1069 буюу 40 хувь нь ажилгүй, 680 буюу 25.4 хувь нь малчин, 440 буюу 16.5 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 201 буюу 7.5 хувь нь төрийн албан хаагч эзэлж байгаа нь бусад салбараас өндөр хувийг эзэлж байна.





#### **5.4 Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдийг эрүүлжүүлэх, саатуулах үйл ажиллагаа:**

Нийт 844 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 204 буюу -19.5



хувиар буурчээ. Эрүүлжүүлэгдсэн хүний:

**33** буюу **3.9** хувь нь **ЭМЭГТЭЙ ХҮН**



**4** буюу **0.5** хувь нь **18 хүртэлх насны**



**13** буюу **1.5** хувь нь **төрийн албан хаагч** эрүүлжүүлэгдсэн байна.

Эрүүлжүүлэгдсэн хүний 130 буюу 15.4 хувийг гудамж талбайгаас, 659 буюу 78 хувийг гэр, орон сууцнаас, 27 буюу 3.1 хувийг байгууллага, аж ахуйн нэгжээс, 11 буюу 1.3 хувийг зочид буудлаас, 12 буюу 1.4 хувийг бар цэнгээний газраас тус тус эрүүлжүүлэгдсэн байна.

#### **НЭГ: ДҮГНЭЛТ**

Аймгийн хэмжээнд 2021 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

#### **НЭГ. ХҮЛЭЭН АВСАН ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТАЛААР:**

1.1. Тус цагдаагийн газарт 2021 онд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 4516 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 328 нэгжээр буюу 6.7 хувиар буурсан байна.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалтай холбоотойгоор иргэд, аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл буурсан эерэг үзүүлэлттэй байгаа хэдий ч Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт архи, согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдан борлуулах үйл ажиллагааг тодорхой хугацаанд хязгаарлаж, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан үе шаттайгаар хэвийн горимд шилжүүлсэн хугацаанд иргэд архи, согтууруулах ундааг нэг дор их хэмжээгээр хэрэглэх, ахуйн хүрээнд бүлэг бөөгнөрөл үүсгэж архидан согтуурах явдал ихсэж улмаар “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-ийн хохирогч, холбогдогч болох, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, танхайрах, хүний биед халдах, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах зэрэг согтуугаар үйлдэгддэг тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчил өсөх шалтгаан болсон гэж дүгнэж байна.

Коронавирус (covid-19)-ын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор хөл, хорио цээрийн дэглэм тогтоож, зарим төрлийн аж, ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зогсоож, хот хоорондын зорчих хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон зэрэг нөхцөл байдалтай холбогдуулан иргэд гэр орон сууцаа эзэнгүй орхих тохиолдол багасч, гудамж талбай, олон нийтийн газруудад иргэдийн хөл хөдөлгөөн харьцангуй багассантай холбоотойгоор дээрх төрлийн гомдол, мэдээллийн тоон үзүүлэлт буурсан байна.

1.2 Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар нь нийт хүлээн авч шалгасан гомдол, мэдээллийн ачааллаар орон нутгийн Цагдаагийн газар, хэлтсийн



хэмжээнд ЗУРГААДУГААРТ, хангайн бүсийн 6 аймгаас ДОЛООДУГААРТ эрэмбэлэгдэж байна.

## **ХОЁР. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААР:**

2.1. Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газарт 2021 онд нийт 428 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34 нэгжээр буюу 7.4 хувиар буурсан.

2.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн өсөлт, бүүралтыг Эрүүгийн хуулийн бүлгээр нь авч үзвэл: Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүнийг алах гэмт хэрэг 50 хувиар, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 25.1 хувиар, тээврийн хэрэгслийн хулгай 3 дахин, дээрэмдэх гэмт хэрэг 3 дахин, залилах гэмт хэрэг 35.71 хувиар, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 7.5 дахин **тус тус өсч**, хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 50 хувиар, хүчиндэх гэмт хэрэг 27.2 хувиар, хулгайлах гэмт хэрэг 16.2 хувиар, мал хулгайлах гэмт хэрэг 68.1 хувиар, хөдөлгөөний аюулгүй байдал журмын ашиглалтын эсрэг гэмт хэрэг 24 хувиар, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 49 хувиар, бусад гэмт хэрэг **2.7 тус тус буурсан**.

2.3. Бүртгэгдсэн хэргийн 179 гэмт хэргийн 41.8 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 145 буюу 33.8 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд эдгээр 2 бүлгийн гэмт хэрэг нь нийт хэргийн 75.7 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь сүүлийн жилүүдэд тогтвортой байгаа үзүүлэлт юм.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 55.8 хувь нь Баянхонгор суманд үйлдэгдсэн бөгөөд Баянхонгор суманд үйлдэгдсэн гэмт хэрэг 13.2 хувиар өсч, бусад сумдад үйлдэгдсэн гэмт хэрэг 24.7 хувиар буурсан нь аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг 7.4 хувиар буурахад шууд нөлөөлсөн.

Мөн зонхилон үйлдэгддэг мал хулгайлах, иргэдийн өмчийг хулгайлах гэмт хэргүүд буурсан нь нийт хэрэг буурахад нөлөөлсөн.

2.4. Нийт гэмт хэргийн гаралтаар орон нутгийн хэмжээнд 2021 оны байдлаар АРВАН НЭГДҮГЭЭРТ, хангайн бүсийн хэмжээнд ГУРАВДУГААРТ байгаа нь бусад орон нутагтай харьцуулахад эрүү хэв журмын нөхцөл байдал хүнд, алба хаагчид ачаалалтай ажиллаж байна гэж дүгнэхээр байна. Гэмт хэргийн гаралтаар НЭГДҮГЭЭРТ Төв аймаг 750, ХОЁРДУГААРТ Хөвсгөл аймаг 716, ГУРАВДУГААРТ Сэлэнгэ, Хэнтий аймаг тус тус 637 гэмт хэрэг бүртгэгдэн гэмт хэргийн гаралтаар эхний 3 аймагт багтаж байна.

2.5 Коронавируст халдвар /Ковид-19/-ын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор Аймгийн онцгой комиссын шийдвэрээр аж, ахуйн нэгжүүдэд цагийн хязгаарлалт тогтоосон, үзвэр үйлчилгээний газруудын үйл ажиллагааг зогсоож, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах үүднээс байнгын болон түр пост, хөдөлгөөнт эргүүлийг ажиллуулсан зэрэг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан авсан арга хэмжээнээс шалтгаалан хулгайлах, алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших, мал хулгайлах төрлийн гэмт хэрэг буурсан эерэг үзүүлэлттэй.

Харин залилах гэмт хэрэг 35.7 хувиар өссөн. Тэр дундаа энэ төрлийн гэмт хэрэг нь цахим орчинд үйлдэгдэх тохиолдол өссөөр байгаа нь онцгой анхаарал татаж байна.

Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин хүч нэмэгдүүлэн ажиллаж гудамж талбай, олон нийтийн газруудад эргүүл шалгалтыг тогтмол зохион байгуулж ажилласнаар мал хулгайлах гэмт хэрэг 68.1 хувиар, орон нутгийн зам дээр үйлдэгддэг хөдөлгөөний аюулгүй байдал журмын эсрэг /зам тээврийн осол, аваар/ гэмт хэрэг 24 хувиар тус тус буурсан бодитой үр дүн гарсан байна.

#### **ГУРАВ. ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТИЙН ТАЛААР:**

3.1. Гэмт хэргийн илрүүлэлт аймгийн хэмжээнд 56.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 пунктээр буурсан.

3.2. Хэрэг бүртгэлтийн 210 хэрэг бүртгэгдсэнээс 119 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж гэмт хэргийн илрүүлэлт 56,6 хувьтай байна. Нийт хэрэг бүртгэлтийн хэрэг өмнөх оны мөн үеэс 31.1 хувиар буурсан нь цагдаагийн алба хаагчдаас мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй явуулах, гэмт хэргийг халуун мөрөөр нь илрүүлэх ажиллагаа сайжирсны нэг илрэл юм.

#### **ДӨРӨВ. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛД ХОЛБОГДОГЧИЙН ТАЛААР:**

4.1. Гэмт хэрэг, зөрчилд холбогдогчдийн нийгмийн байдлаар нь авч үзэхэд гэмт хэрэгт холбогдсон иргэдийн 139 буюу 35.5 хувь нь, гэмт хэрэгт өртөж хохирогчдийн 114 буюу 26.3 хувь нь тус тус малчин иргэд байгаа нь тэдний хууль, эрх зүйн мэдлэг, мэдээлэл дутмаг байгаатай холбоотой гэж дүгнэж байна.

#### **ТАВ. ЗӨРЧЛИЙН ТАЛААР:**

5.1. Аймгийн хэмжээнд 2021 оны 12 дугаар сард нийт 17722 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.5 хувиар буурсан.

Зөрчил гаргасан нийт 16138 иргэнийг 928777.8 төгрөгөөр торгосон. Үүнээс 14141 буюу 87.6 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчсөн зөрчил байна.

5.2. Энэ хугацаанд эрүүлжүүлэгдсэн хүн 844 нэгжээр буюу 19.5 хувиар буурсан. Коронавируст халдвар /Ковид-19/-ын халдвараас урьдчилан сэргийлэх, бүлэг бөөгнөрөл үүсгэхгүй байж, халдвар хамгааллын дэглэмийн сахих үүднээс иргэдийг эрүүлжүүлэх саатуулах байранд хүргэлгүйгээр аль болох ар гэр, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч ажилласнаар эрүүлжүүлэгдсэн хүний тоо буурахад нөлөөлөх хүчин зүйлийн болсон.

Энгийн үед гудамж талбай, байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн газраас /бар, караоке, буудал г.м/ иргэд ихээр эрүүлжүүлэгддэг бол хөл хориотой холбоотойгоор гэр орон сууц, ахуйн хүрээнээс эрүүлжүүлэгдэж байгаа иргэдийн тоо их харагдаж байна.

2021 оны 12 дугаар сард нийт эрүүлжүүлэгдсэн хүний 93.4 хувь нь ахуйн хүрээнээс эрүүлжүүлэгдсэн байгаа нь гэр бүл, ахуйн хүрээнд архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэх тохиолдол их байгаатай холбоотой байна.

#### **САНАЛ**

1. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг болон гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Нэг хором” урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг аймгийн ГХУСАЗСЗ болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах,
2. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр “Жаргалтай амьдрал” төвтэй хамтран ажиллах, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн криминологи судалгааны хүрээнд боловсруулсан зөвлөмжийг хэрэгжүүлэх

3. Залилах болон цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд чиглэсэн мэдээлэл, сургалтууд, нөлөөллийн ажил арга хэмжээ зохион байгуулах,
4. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил удаа дараа үйлдэж буй иргэдэд чиглэсэн нэг бүрчилсэн хяналтыг хэрэгжүүлэх,
5. Гэмт хэргийн гаралт өсөлттэй байгаа баг, сумдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөө сумдын иргэд, малчдыг мэдээллээр хангах, тэдэнд хууль, эрх зүйн мэдлэг олгох зорилгоор сумдад урьдчилан сэргийлэх ажил, сургалт, сурталчилгааг зохион байгуулах,
6. Насанд хүрээгүй иргэн холбогдсон гэмт хэрэг, зөрчлийн гаралт өсч байгаад анхаарч, гэмт хэрэгт холбогдсон, хохирсон насанд хүрээгүй хүнд сэтгэл зүйн зөвлөгөө тусламж үзүүлэх, гэмт хэрэг, зөрчилд өртөж, холбогдож болзошгүй хүүхдүүдийг бүртгэлжүүлж эцэг, эх асран хамгаалагч нартай нь байнгын уялдаа холбоотой ажиллах, хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд холбон зуучлах, цахим хэлбэрээр өсвөр насны хүүхдүүдэд сургалт сурталчилгааг тогтмол явуулах,